

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/282/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ӨГӨӨМӨР ЦЭЦЭРЛЭГИЙН  
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: [rsamongolia@gmail.com](mailto:rsamongolia@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУГ	Боловсрол Шинжлэх Ухааны Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024. 02. 25 № 01/153  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ  
СУМЫН ӨГӨӨМӨР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Л.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 7 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж 98,0 хувиар хэрэгжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

## Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эхний үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	125,909,871.83	83,513,635.13
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	88,757,182.28	47,786,115.58
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	88,757,182.28	47,786,115.58
9	Төгрөг	88,757,182.28	47,786,115.58
10	Төрийн сангийн харилцах	88,757,182.28	47,786,115.58
60	БАРАА МАТЕРИАЛ	37,152,689.55	35,727,519.55
66	Хангамжийн материал	37,152,689.55	35,727,519.55
67	Бичиг хэргийн материал	-	30,800.00
68	Аж ахуйн материал	-	366,000.00
70	Түлш шатах тослох материал	4,332,800.00	1,755,200.00
72	Хүнсний материал	1,251,420.00	1,320,300.00
73	Бусад хангамжийн материал	31,568,469.55	32,255,219.55
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	862,521,548.88	791,208,041.02
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	862,521,548.88	791,208,041.02
108	Биет хөрөнгө	858,221,548.88	786,908,041.02
109	Барилга, байгууламж	887,136,068.78	803,919,150.97
110	Хуримтлагдсан элэгдэл	(65,739,133.20)	(58,549,933.08)
113	Машин, тоног төхөөрөмж	30,864,168.00	43,706,968.00
114	Хуримтлагдсан элэгдэл	(14,545,791.50)	(19,861,371.51)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,423,062.12	30,973,282.72
116	Хуримтлагдсан элэгдэл	(12,980,738.32)	(15,107,705.52)
122	Бусад үндсэн хөрөнгө	11,972,527.00	11,972,527.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(11,500,000.00)	(11,736,263.56)
125	Номын фонд	1,591,386.00	1,591,386.00
126	Биет бус хөрөнгө	4,300,000.00	4,300,000.00
129	Бусад биет бус хөрөнгө	4,300,000.00	4,300,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	988,431,420.71	874,721,676.15
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	988,431,420.71	874,721,676.15
215	Засгийн газрын хувь оролцоо	988,431,420.71	874,721,676.15
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	226,954,332.77	226,954,332.77
217	Өмч: -Төрийн өмч	226,954,332.77	226,954,332.77
223	Хуримтлагдсан үр дүн	676,700,121.24	638,370,702.28
224	Өмнөх үеийн үр дүн	676,700,121.24	752,080,446.84
225	Тайлант үеийн үр дүн	-	(113,709,744.56)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	84,776,966.70	9,396,641.10
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	988,431,420.71	874,721,676.15

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,323,947,190.76	339,989,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,300,535,575.76	316,151,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	921,969,775.76	11,412,800.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	29,490,679.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	29,490,679.00	-
120017	Монгол банкны ашиг	865,898,263.21	11,412,800.00
120018	Бусад орлого	26,580,833.55	-
122	Тусламжийн орлого	378,565,800.00	304,738,800.00
122005	Хандив тусламж /дотоод/	378,565,800.00	304,738,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,411,615.00	23,837,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,411,615.00	23,837,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,411,615.00	23,837,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	326,453,920.46	396,080,947.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	326,453,920.46	396,080,947.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	317,613,920.46	389,076,343.32
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	195,255,327.09	254,652,605.54
210101	Цалин	152,052,105.05	186,071,643.94
210102	Нэмэгдэл цалин	37,733,702.04	62,569,247.20
210104	Урамшуулал	5,469,520.00	6,011,714.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,395,235.63	32,137,573.92
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	17,301,510.73	22,036,195.80
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,079,120.95	2,539,663.58
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,533,621.80	1,997,890.92
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	461,338.65	472,712.35
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,019,643.50	5,091,111.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,863,549.00	21,451,395.57
210301	Гэрэл цахилгааны зардал	5,883,887.00	5,018,095.57
210302	Түлш, халаалтын зардал	11,849,662.00	14,725,300.00
210303	Цэвэр, бохир усны зардал	3,130,000.00	1,708,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,503,750.00	3,303,750.00
210401	Бичиг хэргийн материал	2,776,000.00	117,000.00
210402	Тээвэр, шатахууны зардал	-	2,100,550.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	727,750.00	1,086,200.00
2105	Нормативт зардал	42,697,000.00	42,814,870.00
210501	Эм	-	82,500.00
210502	Хоол	42,376,150.00	42,732,370.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	320,850.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00

2107	Томилолт, зочны зардал	-	520,000.00
210702	Дотоод томилолтын зардал	-	520,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	76,165.00	3,132,827.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,550,750.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	76,165.00	582,077.24
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,322,893.74	30,563,321.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,022,950.00	-
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	1,879,360.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,299,943.74	28,683,961.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,840,000.00	7,004,604.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,840,000.00	2,373,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	8,840,000.00	2,373,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	4,630,804.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,630,804.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	997,493,270.30	(56,091,647.75)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	9,061,849.59	57,618,096.81
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	9,061,849.59	57,618,096.81
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(9,061,849.59)	(57,618,096.81)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	988,431,420.71	(113,709,744.56)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	401,977,415.00	328,576,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	378,565,800.00	304,738,800.00
122	Тусламжийн орлого	378,565,800.00	304,738,800.00
122005	Хандив тусламж /дотоод/	378,565,800.00	304,738,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,411,615.00	23,837,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,411,615.00	23,837,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,411,615.00	23,837,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	308,370,232.72	364,916,762.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	308,370,232.72	364,916,762.27
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	299,530,232.72	362,542,962.27
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	190,405,327.06	254,652,605.54
210101	Үндсэн цалин	147,202,105.22	186,071,643.94
210102	Нэмэгдэл	37,733,701.84	62,569,247.20
210104	Үр дүнгийн урамшуулал	5,469,520.00	6,011,714.40
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	25,395,235.66	32,137,573.92

210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	17,301,510.73	22,036,195.80
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,079,120.95	2,539,663.58
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,533,622.00	1,997,890.92
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	461,338.65	472,712.35
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,019,643.33	5,091,111.27
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	22,911,615.00	18,706,895.57
210301	Гэрэл цахилгааны зардал	5,883,887.00	5,018,095.57
210302	Түлш, халаалтын зардал	13,897,728.00	11,980,800.00
210303	Цэвэр, бохир усны зардал	3,130,000.00	1,708,000.00
2105	Нормативт зардал	43,067,190.00	42,801,250.00
210502	Хоол, хүнс	43,067,190.00	42,801,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,165.00	624,077.24
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	76,165.00	624,077.24
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,174,700.00	13,120,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,433,700.00	11,133,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	4,741,000.00	1,987,160.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,840,000.00	2,373,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,840,000.00	2,373,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	8,840,000.00	2,373,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	93,607,182.28	(36,340,262.27)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	93,607,182.28	(36,340,262.27)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	88,757,182.28
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	88,757,182.28	47,786,115.58

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	ДАНС	511.00	51,300.00	51210+51220	
C01	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	-	-
C08	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгд	226,954,332.77	84,776,966.70	676,700,121.24	988,431,420.71
D01	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгд	226,954,332.77	84,776,966.70	676,700,121.24	988,431,420.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	-	-	75,380,325.60	75,380,325.60
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	226,954,332.77	84,776,966.70	752,080,446.84	1,063,811,746.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний	-	(75,380,325.60)	-	(75,380,325.60)
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг а	-	-	(113,709,744.56)	(113,709,744.56)
D09	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгд	226,954,332.77	9,396,641.10	638,370,702.28	874,721,676.15

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	88,757,182.28	(88,757,182.28)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	417,333,700.00	364,916,762.27	52,416,937.73	87.4
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	417,333,700.00	364,916,762.27	52,416,937.73	87.4
210	Бараа, үйлчилгээний зардал	414,959,900.00	362,542,962.27	52,416,937.73	87.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,092,200.00	254,652,605.54	35,439,594.46	87.8
210101	Үндсэн цалин	198,835,300.00	186,071,643.94	12,763,656.06	93.6
210102	Нэмэгдэл	83,623,800.00	62,569,247.20	21,054,552.80	74.8
210104	Урамшуулал	7,633,100.00	6,011,714.40	1,621,385.60	78.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,260,800.00	32,137,573.92	4,123,226.08	88.6
210201	Тэтгэврийн даатгал	24,657,500.00	22,036,195.80	2,621,304.20	89.4
210202	Тэтгэмжийн даатгал	2,900,800.00	2,539,663.58	361,136.42	87.6
210203	ҮОМШӨ ний даатгал	2,320,600.00	1,997,890.92	322,709.08	86.1
210204	Ажилгүйдлийн даатгал	580,300.00	472,712.35	107,587.65	81.5
210205	Эрүүл мэндийн даатгал	5,801,600.00	5,091,111.27	710,488.73	87.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,337,700.00	18,706,895.57	4,630,804.43	80.2
210301	Гэрэл цахилгаан	8,006,800.00	5,018,095.57	2,988,704.43	62.7
210302	Түлш, халаалт	13,530,900.00	11,980,800.00	1,550,100.00	88.5
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,708,000.00	92,000.00	94.9
2105	Нормативт зардал	47,998,000.00	42,801,250.00	5,196,750.00	89.2
210502	Хоол, хүнс	47,998,000.00	42,801,250.00	5,196,750.00	89.2
2106	Эд хогшил худалдан авах	500,000.00	500,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	730,400.00	624,077.24	106,322.76	85.4
210806	Мэдээллийн технологийн зардал	730,400.00	624,077.24	106,322.76	85.4
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	16,040,800.00	13,120,560.00	2,920,240.00	81.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,849,600.00	11,133,400.00	2,716,200.00	80.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,191,200.00	1,987,160.00	204,040.00	90.7
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,373,800.00	2,373,800.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,373,800.00	2,373,800.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,373,800.00	2,373,800.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	417,333,700.00	328,576,500.00	88,757,200.00	78.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	304,738,800.00	304,738,800.00	-	100.0
122005	Улсын төсвөөс санхүүжих	304,738,800.00	304,738,800.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,837,700.00	23,837,700.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	23,837,700.00	23,837,700.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАНААС	88,757,200.00	-	88,757,200.00	-
120004	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	88,757,200.00	-	88,757,200.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	88,757,182.28	(88,757,182.28)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	47,786,115.58	(47,786,115.58)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	15.00	15.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүй хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэг нь 2023 оныг "Залуучуудын хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 7 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 98,0 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус цэцэрлэг нь 17 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал,заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 он 11 сард аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдсан. 95,7 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 113,709.7 мянган төгрөгөөр буюу 11,5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	88,757.2	47,786.1	-40,971.1
<b>Авлага</b>			
<b>Урьдчилгаа</b>			
<b>Бараа материал</b>	37,152.1	35,727.5	-1,425.2
<b>Үндсэн хөрөнгө</b>	862,521.5	791,208.0	-71,313.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>988,431.3</b>	<b>874,721.7</b>	<b>-113,709.8</b>
<b>Өр төлбөр</b>			
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	903,654.6	865,325.1	-38,329.5
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	84,776.9	9,396.6	75,830.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>988,431.5</b>	<b>874,721.7</b>	<b>-113,709.7</b>

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 47,786.1 мянган төгрөг өмнөх оноос 40,971.1 мянган төгрөгөөр буурсан нь урьд оны төсвийн гүйцэтгэл өндөр байсан.

Бараа материал дансны үлдэгдэл 35,727.5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 1,425.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь бараа материалын зарцуулалт өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс 70,823.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 2,779.8 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, БШУГ-аас хандиваар компьютер, гал тогооны тоног төхөөрөмжийг 11,412.8 мянган төгрөгөөр тус тус авсан.

Төв аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2023 оны 7-р сарын 06-ны өдрийн 02 тоот тогтоолоор тоног төхөөрөмж данснаас 1,349.0 мянган төгрөг, тээврийн хэрэгсэл 449.7 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус акталсан.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 304,738.8 мянган төгрөг, орон нутгаас 23,837.7 мянган төгрөг, нийт зарлагыг

328,576.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 328,576.5 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 328,576.5 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 328,576.5 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 364,916.8 мянган төгрөг буюу 87,4 хувьтай байгаа нь: Үндсэн цалин 12,754,613.2 мянган төгрөгөөр, Нэмэгдэл цалинг 21,063,595.6 мянган төгрөгөөр, Тэтгэврийн даатгал 2,621,304.2 мянган төгрөгөөр, Тэтгэмжийн даатгал 361,136.4 мянган төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгал 322,709.1 мянган төгрөгөөр, Ажилгүйдлийн даатгал 107,587.7 мянган төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгал 710,488.7 мянган төгрөгөөр, Гэрэл цахилгааны зардал 2,988,704.4 мянган төгрөгөөр, Түлш, халаалт 1,550.100 мянган төгрөгөөр, Цэвэр, бохир ус 92,000 мянган төгрөгөөр, Хоол хүнсний зардал 5,196.750 мянган төгрөгөөр, Хүнсний материалд 2,920.240 мянган төгрөгөөр тус тус хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,385.6	897.5	488.1	64.8%
2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	47,156.5	42,801.3	4,355.2	90.8%
3	81823- Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,201.6	1,140.0	61.6	94.9%
4	81832- Нүүдлийн бүлэгт хамруулах	6,043.4	4,371.0	1,672.4	72.3%
5	81833- Явуулын багшийн үйлчилгээ	1,325.9	550.4	775.5	41.5%
6	81834- Боловсролын стандарт	265,455.7	239,407.8	26,047.9	90.2%
7	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	67,999.0	53,613.5	11,385.5	78.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	64.8%	1,385.6	897.5
2	71801-81807	2023-12-31	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	90.8%	47,156.5	42,801.3
3	71801-81823	2023-12-31	Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	94.9%	1,201.6	1,140.0
4	71801-81832	2023-12-31	Нүүдлийн бүлэгт хамруулах	72.3%	6,043.4	4,371.0
5	71801-81833	2023-12-31	Явуулын багшийн үйлчилгээ	41.5%	1,325.9	550.4
6	71801-81834	2023-12-31	Боловсролын стандарт	90.2%	265,455.7	239,407.8
7	71801-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	78.8%	67,999.0	53,613.5

Цэцэрлэгийн хүүхдийн хоол арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь сургуулийн хүүхдийн улирлын амралт эхэлж, ирц багасдагтай холбоотойгоор хэмнэгдсэн. Нүүдлийн бүлэгт хамруулах арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь орон тоо хэмнэсэн, хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн.

Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь томуу томуу төст өвчин ихэссэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурч хэмнэгдсэн.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэг нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Сумын албан бичгээр Арвинбат ХХК-аас хүнс- 42,801.2 мянган төгрөгийн хүүхдийн хоолонд хэрэглэх хүнсний материалыг шууд худалдан авалтаар худалдан авалт хийсэн.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг

барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК -ийн ахлах аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 310,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 6,200.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,960.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 35,493.6 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 4,631.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус Хүүхдийн цэцэрлэг нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 153 мэдээллийг байршуулж 6 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай

мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүнба өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэг нь эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 2 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмж үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1				100
Нийт дүн	1				100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал байхгүй

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,793.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,793.7 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### 5.3 Зөвлөмж

1.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2023 оны 04-р сард хүүхдийн хоолны хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг орц нормын дагуу бодогдоогүй байна. Энэ нь Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02

өдрийн А\166, 222, 279 дугаар хамтарсан тушаалын 2-р хавсралт 1,2 1-3 нас, 4-6 насны заалтын дагуу хүүхдийн хоолны нормыг баримтлан ажиллаагүй, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Цаашид дээрх тушаалд дурдсан хоолны орц нормыг баримтлан ажиллахыг ахлах тогооч мөрдөж, нягтлан бодогч хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
2023 оны 4-р сард хүүхдийн хоолны хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг орц нормын дагуу бодоогүй	1	1,793.7					1	1,793.7				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,793.7</b>					<b>1</b>	<b>1,793.7</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)